



## ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 4/241

Улиастай

### “Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.3.4 дэх зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангаж, дотуур байрын орчин нөхцөлийг сайжруулах, багш, ажилчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх “Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээг нэгдүгээр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, нэгтгэн тайлагнахыг Боловсрол, соёл урлагийн газар (Д.Бямбацогт), хэрэгжилтийг хариуцан ажиллахыг сургуулийн захирал, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусган санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ж.Хүрэлбаатар), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Ж.Батцэнгэл)-т даалгасугай.

4.“Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээний хэрэгжилтийг хагас жил тутамд тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (А.Шаравжамц), хэрэгжилт, тайланд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (Н.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ТҮВШИНЖАРГАЛ

E/zakhiramj2021

811212715

Аймгийн Засаг даргын 2021 оны 06  
дугаар сарын 19-ны өдрийн  
4/241 дугаар захирамжийн  
нэгдүгээр хавсралт

## “ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ДОТУУР БАЙР” АРГА ХЭМЖЭЭ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

8119285296 9039287

Нүүдлийн соёл иргэншилтэй манай орны хувьд малчин өрхийн хүүхдэд боловсрол эзэмшүүлэхэд шаардлагатай зүйлийн нэг бол дотуур байрын үйлчилгээний чанар, хүртээмжийн тухай асуудал юм. 2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 29 сургууль, СУИС-ийн харьяа хөгжим бүжгийн коллеж 1, нийт 30 сургуулийн 622 бүлэгт **15535** хүүхэд суралцаж байгаагийн **6203** буюу 39,9 хувь нь малчдын хүүхэд суралцаж байна. Дотуур байранд амьдарч байгаа нийт хүүхдүүдийн 90 гаруй хувь нь малчин өрхийн хүүхдүүд байна.

**Хүүхдийн эрхийн тухай /2016 он/ хуулиар /1/ хүүхэд эсэн мэнд амьдрах, /2/ хөгжих, /3/ хамгаалуулах, /4/ нийгмийн амьдралд оролцох** эрхтэй бөгөөд орон нутагт Хүүхдийн төлөө зөвлөлийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга тэргүүлж, “хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд нийгмийн нөөц баялгийг дайчлах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах”-ыг тодорхойлсон байдаг.

#### **Хүүхэд хамгааллын тухай /2016 он/ хуулиар**

/5.1./ Эцэг, эх, гэр бүлийн гишүүд, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь хүүхэдтэй холбоотой эрх, үүргээ урвуулан ашиглах, хүүхдийг үл хайхрах, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, аливаа гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалах арга хэмжээ авна.

/5.2./ Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсч хөгжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд хуульд заасны дагуу эвлэлдэн нэгдэх, шаардлага, өргөдөл, гомдол, мэдээлэл гаргаж, түүнийг шийдвэрлүүлэх замаар хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.

/5.4./ Эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч нь хүүхдийг өсгөн хүмүүжүүлэх, боловсрол олгох, асран хамгаалахдаа хүчирхийллээс ангид хүмүүжлийн арга хэрэглэнэ.

/6.1./ Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөж ажиллана.

/6.3.1./ Сургалтын байгууллагын багш, ажилтан хүүхэд хүмүүжүүлэх зэрэг арга эзэмших;

/6.3.2./ Сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах, зөвлөгөө өгөх гэж тодорхой заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд

**“Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны**

**хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ”** гэсэн зорилт дэвшүүлж, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг

/2.1.19./ Сургуулийн дотуур байр, ногоон хөгжлийн байгууламж, спортын болон урлагийн заал, цайны газар, мэдээлэл зүйн сургалтын танхимыг тохижуулж, сургалтын байгууллагын орчны стандартыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан тохируулгат орчныг бүрдүүлж, цэвэр ус, ариун цэврийн байгууламжийг хүүхэд, хэрэглэгчдэд ээлтэй болгох ажлыг үе шаттайгаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

/2.1.24./ Сургуулийн дотуур байрын менежментийг сайжруулан багш нарын ажлын ачааллын 10 хүртэлх хувьд дотуур байранд сурагчдын хөгжлийг дэмжих чиглэлээр хийсэн сургалт, хөгжлийн үйл ажиллагааны цагийг тооцдог байх зохицуулалт хийж, дотуур байрны хүүхэд хамгааллыг сайжруулна.

/2.1.26./ Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний тогтолцоог хөгжүүлэн бүх сурагч үдийн хоолны хөтөлбөрт хамрагдаж, сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй байна гэж төлөвлөсөн байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д

/2.1.8./ Газарзүйн мэдээллийн системд үндэслэн сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хүртээмжийг нэмэгдүүлэн, тэгш байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ.

/2.1.9./ Цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоолны зардлыг хоёр дахин нэмэгдүүлнэ гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Хүний хөгжлийн бодлого”-ын “Боловсрол” хэсэгт **“ Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ ”** гэсэн зорилт дэвшүүлэн

- **Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх,**
- **Жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох**
- **Цэцэрлэг, дотуур байр, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны зардлыг инфляц, үнийн өсөлттэй уялдуулан 2-оос доошгүй дахин нэмэгдүүлж, сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангана** гэсэн зорилт дэвшүүлсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д

- Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.
- Сургалтын орчны аюулгүй байдлыг сайжруулна гэсэн зорилгыг дэвшүүлэн,

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн “Боловсрол” хэсэгт **“Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон, насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ”** гэсэн зорилгыг дэвшүүлж

- Боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ.
- Сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байрын орчны гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ.
- Боловсролын байгууллагыг стандартад нийцсэн ус, ариун цэврийн байгууламжаар хангахад дэмжинэ гэсэн зорилт дэвшүүлсэн.

### **Завхан аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын өнөөгийн нөхцөл байдал**

Аймгийн Ерөнхий боловсролын 30 сургуульд 15535 хүүхэд суралцаж, байгаагийн 1500 хүүхэд нь дотуур байранд суух хүсэлт өгч, 1396 суралцагч )1-5-р ангийн 431, 6-9-р ангийн 634 суралцагч, 10-12-р ангийн 331( дотуур байранд амьдарч байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 26 дотуур байрын 25 нь стандартын, 1 дотуур байр стандарт бус барилгад үйл ажиллагаа явуулж, дотуур байранд амьдарч буй 1396 хүүхдийн 694 нь буюу 50% нь эмэгтэй хүүхэд байна.

Аймгийн Засаг даргын санаачилгаар дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, ая тухтай орчин бүрдүүлэх зорилгоор “Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан.

2020 оны байдлаар ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт 96.1%, 6 настай хүүхдийн сургуулийн хамран сургалт 99%, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 83.7 % байна.

Аймгийн хэмжээнд Хүүхдийн цэцэрлэгийн 10%, ЕБС-ийн 15% нь сайжруулсан ус, ариун цэврийн байгууламжтай байна.

Дотуур байрын барилгын 60% ашиглалтын хугацаа дууссан, 1970-1982 онд баригдсан барилгад үйл ажиллагаа явуулж байна.

БСШУСЯ-ны Ерөнхий боловсролын бодлогын газар, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 2017 онд зохион байгуулсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн өнөөгийн байдал” судалгааны үр дүнгээс үзэхэд нийт дотуур байрын 85% нь гадаа байрлах нүхэн жорлонтой, 15% нь дотор байрлах ариун цэврийн өрөөтэй, 20% нь сурагчдын халуун усанд орох боломжийг бүрдүүлсэн байна.

Сүүлийн 10 жилийн судалгаанаас үзвэл дотуур байрын хүүхдийн орны тоо нэмэгдээгүй, 5 дотуур байранд төслийн хөрөнгөөр их засвар хийгдсэн, бусад дотуур байранд их засвар хийгдээгүй ба малчид гэр бүлээрээ малаа хариулах, хүүхдээ сургуулийн дотуур байранд амьдруулах зайлшгүй хэрэгцээ, шаардлагаас дотуур байранд амьдрах хүсэлт өгөх хүүхдийн тоо жил ирэх тусам нэмэгдсээр байна.

### **ХОЁР. ЗАРЧИМ**

“Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээний зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

1. Хүүхдийн эрхийг хүндэтгэн, хүүхдийн хөгжил, төлөвшил, аюулгүй байдал, эерэг харилцаа хандлагыг эрхэмлэнэ.
2. Дотуур байрын үйл ажиллагаанд хүүхдийн хувийн онцлогийг харгалзан, монгол ёс заншил, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг эрхэмлэнэ.
3. Дотуур байранд дэвшилтэт технологид суурилсан хүүхдийн хөгжлийн орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

### **ГУРАВ. ЗОРИЛГО**

“Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээний зорилго нь хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангаж, дотуур байрын орчин нөхцөлийг сайжруулах, багш, ажилчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэн, хүүхдэд ээлтэй дотуур байрыг хөгжүүлэхэд оршино.

### **ДӨРӨВ. ЗОРИЛТ**

- 4.1. Дотуур байранд хүүхдийн хөгжих эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, дотуур байрын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, байранд амьдарч байгаа хүүхдийн тоог нэмэгдүүлэх;
- 4.2. Дотуур байрыг хүүхдэд ээлтэй, ая тухтай орчин бүрдүүлэхэд чиглэсэн тоног төхөөрөмж, тоглоом наадгай, ус, ариун цэврийн байгууламжаар хангах;
- 4.3. Дотуур байрын багш, ажилтан, сургуулийн удирдлага, багш, ажилтан, эцэг, эх асран хамгаалагч, суралцагчдад хүүхдийн эрх, хамгаалал, эерэг харилцааны сургалт зохион байгуулан, мэдлэг, ур чадвар, дадал, харилцаа, хандлагыг дээшлүүлэх;
- 4.4. Дотуур байрын тогооч нарын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, байрын гал тогоог дэвшилтэд техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, хоолны амт, чанарыг сайжруулах;

### **ТАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА**

- 5.1. “Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

### **ЗУРГАА. САНХҮҮЖИЛТ**

- 6.1. “Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:
  - 6.1.1. улсын болон орон нутгийн төсөв;
  - 6.1.2. байгууллагын өөрийн хөрөнгө, орлого;
  - 6.1.3. иргэн, аж ахуйн нэгжийн хандив;

- 6.1.4. олон улсын болон гадаад улсын зээл, тусламж;  
6.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр;

## **ДОЛОО. ХҮРЭХ ҮР ДҮН**

- 7.1 Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр нь Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны С/40 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 6781:2019” стандартыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байх.
- 7.2 Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байр нь Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны С/62 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 6890:2020” стандартыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байх.
- 7.2 Дотуур байр нь Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн С/58 дугаар тушаалаар батлагдсан “Сургалт, хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага MNS 6799:2019” стандартыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байх.

## **НАЙМ. ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ**

- 8.1. “Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээг аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах, зөвлөн туслах, хяналт, үнэлгээ хийх ажлыг аймгийн БСУГ хариуцна.
- 8.2. “Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээг сумын түвшинд хэрэгжүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих, үр дүнг тайлагнах ажлыг сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан, сумын Засаг даргын орлогч, сумын Засаг даргын Тамгын газрын дарга, багийн Засаг дарга, сургуулийн захирал, төрийн болон төрийн бус байгууллага, эцэг эхийн төлөөллөөс бүрдсэн “Ажлын хэсэг” хариуцан ажиллана.
- 8.3. “Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээг хэрэгжүүлэх сумын “Ажлын хэсэг” хэрэгжилтийн тайлан, мэдээг БСУГ-т 6 дугаар сарын 20-ны дотор хагас жилээр, 12 дугаар сарын 20-ны дотор бүтэн жилээр цаасаар болон цахимаар, хугацаанд нь ирүүлж ажиллана.
- 8.4. “Хүүхдэд ээлтэй дотуур байр” арга хэмжээний хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2 жил тутам үнэлгээ хийж ажиллана.
- 8.5. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь нутаг дэвсгэрийн хэмжээнд арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах төсвийг баталж, хэрэгжилтийн дүнг хэлэлцэн, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн идэвх санаачилгыг дэмжин хамтарч ажиллана.

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 сарын  
17 өдрийн 17/21 дугаар захирамжийн  
хоёрдугаар хэсэрт

"ХҮҮХДЭД ЭЭЛТЭЙ ДОТУУР БАЙР" АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ /2021-2024 ОН/

(сая төгрөгөөр)

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ 2021-2024	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2021 он		2022 он		2023		2024		Хэрэгжүүлэгч байгууллага		
						Хүрэх түвшин, ҮР ДҮН	Төсөв	Хүрэх түвшин, ҮР ДҮН	Төсөв	Хүрэх түвшин, ҮР ДҮН	Төсөв	Хүрэх түвшин, ҮР ДҮН	Төсөв	Үндсэн	Хамтрагч	Оролцогч
Нэг. "Дотуур байранд хүүхдийн эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж, дотуур байрын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан, байранд амьдарч байгаа хүүхдийн тоог нэмэгдүүлнэ" зорилтын хүрээнд																
1	Хүүхдэд ээлтэй дотуур байр арга хэмжээг дотуур байртай сургуулиуд хэрэгжүүлэх	БӨХ	0.0	27 дотуур байр хэрэгжүүлнэ.	0	40	0	60	0	80	0	100	0	АЗДТГ, БСУГ	СЗДТГ	ЕБС
2	Дотуур байрын нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулах,	БӨХ	0.0	Эцэг,эх олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.	0	40	0	60	0	80	0	100	0	БСУГ	СЗДТГ	ЕБС
3	Дотуур байранд хүүхдийн авьяас, хүсэл сонирхол, чадварт нь тулгуурлан хүүхдийн оролцоог хангасан сайн дурын клуб, хамтлаг, бүлэг байгуулан ажиллах,	БӨХ	2.0	Хүүхдүүдийн авьяас хөгжүүлэх, хүүхдүүдийн хамтын ажиллагааг сайжирна.	0	40	0.5	60	0.5	80	0.5	100	0.5	БСУГ	СЗДТГ	ЕБС
4	Сургууль, дотуур байрын багш, ажиллагсдын дотуур байрын хүүхдэд нэг бүрт хүрч ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, анги удирдсан багш нарыг дотуур байранд тогтмол ажиллуулах,	БӨХ	2.0	Дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн сурлагын чанар дээшилнэ.	0	40	0.5	60	0.5	80	0.5	100	0.5	БСУГ	СЗДТГ	ЕБС
5	Дотуур байрын хүүхдэд хөгжлийн танхимыг шинээр байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах,	ОНТ	12.0	Дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүд чөлөөт цагаа боловсон өнгөрүүлнэ. Хүүхдэд хөгжинэ.	40	4 дотуур байр	3.0	6 дотуур байр	3.0	7 дотуур байр	3.0	8 дотуур байр	3.0	БСУГ	АЗДТГ	ЕБС
6	Дотуур байр нь хүүхдийн аюулгүй байдлыг хангах аюулгүйн гарц, зураглал, гал унтраах багаж хэрэгсэл бүхий булантай, халтиргаа гулгаанаас хамгаалах шалавч, тэргэнцэр явах замтай болох.	ОНТ	11.0	Хүүхдэд хамгааллын үйл ажиллагаа сайжирна.	40	2 дотуур байр	1.0	4 дотуур байр	2.0	5 дотуур байр	3.0	7 дотуур байр	5.0	БСУГ	АЗДТГ	ЕБС
7	Дотуур байранд "Номын өргөө" байгуулах, дотуур байрын хүүхдүүдэд хуваарийн дагуу сургуулийн биеийн тамирын заал, номын сангаар үйлчлэх,	ТХ	12.0	Ном унших сонирхолтой болно. Өөртөө итгэх өөрийгөө илэрхийлэх аргад суралцана.	0	3 дотуур байр	3.0	60	3.0	4 дотуур байр	3.0	5 дотуур байр	3.0	БСУГ	СЗДТГ	ЕБС
8	Дотуур байрын ширээ, сандал, хувцасны шкаф, ор дэвсгэр, бусад эд хогшил, агааржуулалт, дулаан, гэрэл цахилгаан нь стандартын шаардлага хангасан байх	ОНТ	36.0	Дотуур байрын орчин нөхцөл сайжирна.	60	3 дотуур байр	9.0	4 дотуур байр	9.0	5 дотуур байр	9.0	6 дотуур байр	9.0	БСУГ	АЗДТГ, СЗДТГ	ЕБС

2	Сургуулийн дотуур байрыг хяналтын камертай болгон түүнийг ашиглах, бичлэг хадгалах, хянах дүрэм, журам батлан мөрдүүлэх	ОНТ,	12.0	Хүүхэд хамгааллын үйл ажиллагаа сайжирна.	40	60	3.0	80	3.0	90	3.0	100	3.0	БСУГ	СЗДТГ	ЕБС
3	Дотуур байрын хүүхэд цэвэр ус тогтмол уух боломжийг бүрдүүлэх, ус цэвэршүүлэгч төхөөрөмжтэй болох	ТХ,	12.0	Усыг зөв боловсон хэрэглэх арга зүйд суралцана.	40	60	3.0	80	3.0	90	3.0	100	3.0	БСУГ	СЗДТГ	ЕБС
4	Бага насны болон хөгжлийн баршээлтэй хүүхдэд зориулсан угаагуур шүршүүртэй болгох.	ТХ,	12.0	Орчин нөхцөл сайжирна.	40	60	3.0	80	3.0	85	3.0	90	3.0	БСУГ	СЗДТГ	ЕБС
5	Дотуур байрын нүхэн жорлонг өөрчлөн боловсон нойлтой болох	УТ	0.0	Орчин нөхцөл сайжирна.	40	60	0	70	0	80	0	90	0	БСУГ	СЗДТГ	ЕБС
7	Дотуур байрын зөвлөн эдлэл, хувцасны шүүгээ, орыг үе шаттай шинэчлэх	ОНТ,	16.0	Амьдрах ая тухтай орчин бүрдэнэ.	40	60	4.0	70	4.0	80	4.0	90	4.0	АЗДТГ, БСУГ	СЗДТГ	ЕБС
8	Дотуур байранд эцэг, эхийн эргэлтийн өрөөг байгуулах	ОНТ,	12.0	Сургууль эцэг, эхийн хамтын ажиллагаа сайжирна.	0	40	3.0	60	3.0	80	3.0	90	3.0	БСУГ	СЗДТГ	ЕБС
9	Хүүхэд хөгжлийн танхимын тоглоом наадгайны төрөл, тоог нэмэгдүүлэх, шинэчлэх	ТХ,	8.0	Чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломж нь бүрдэнэ.	0	40	2.0	60	2.0	80	2.0	90	2.0	БСУГ	СЗДТГ	ЕБС
10	Сурагчдын өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, дотуур байрын хүүхдийн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, чадавжуулах	ТХ	1.5	Дотуур байрын зөвлөлийн үйл ажиллагаа сайжирна.	0	40	0	60	0.5	80	0.5	90	0.5	БСУГ	СЗДТГ	ЕБС
2-р заалтын мөнгөн дүн			85.5				21.0		21.5		21.5		21.5			

Гурав. "Дотуур байрын багш, ажилтан, сургуулийн удирдлага, багш, ажилтан, эцэг, эх асран хамгаалагч суралцагчдад хүүхдийн эрх, хамгаалал, эерэг харилцааны сургалт, зохион байгуулан мэдлэг, ур чадвар дадал харилцаа хандлагыг дээшлүүлэх зорилтын хүрээнд

1	Дотуур байр, эцэг эх, хүүхдийн үүрэг хариуцлагыг тусгасан гурван талт хамтарсан гэрээг хичээлийн жилийн эхэнд байгуулж, хичээлийн жилийн төгсгөлд дүгнэн, цаашид авах арга хэмжээний талаар хамтран хэлэлцэж, онцлох асуудлыг дараа жилийн гэрээнд тусгах, эцэг, эхтэй харилцах дэвтэртэй болох	БӨХ,	2.0	Хамтын ажиллагаа сайжирна.	0	40	0.5	60	0.5	80	0.5	90	0.5	БСУГ	ЕБС	эцэг эх, дотуур байрын сурагч
2	Дотуур байрын багш жижүүр, үйлчлэгч нарыг хүүхэдтэй харилцах ур чадварт сургах "Хүүхэд хүмүүжүүлэх" үе шаттай сургалтыг тухайн сургуулийн нийгмийн ажилтан, багш нарыг түшиглэн зохион байгуулдаг байх	ОНТ,	4.0	Дотуур байрын багш ажилтан нарын мэдлэг ур чадвар дээшилнэ.	0	40	1.0	60	1.0	70	1.0	90	1.0	БСУГ	ЕБС	багш, ажилтан
3	Дотуур байрын багш нарыг туршлага судлах сургалт, үйл ажиллагаанд хамруулах	ОНТ,	5.5	Дотуур байрын багш нарын мэдлэг ур чадвар дээшилнэ.	0	40	0	60	2.5	80	1.5	90	1.5	БСУГ	СЗДТГ	ЕБС